



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Журам хүчингүй болгох тухай” 2020 оны А/42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийн дарга /Т.Батмөнх/-д даалгасугай.

3. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/196 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Д.ЗОРИГТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2020 оны 05 дугаар сарын
01-ны өдрийн А/47 тоот тушаалын
хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч (цаашид “Төрийн албан хаагч” гэх)-ийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийг /цаашид “Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөл” гэх/ болон аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дэргэдэх ёс зүйн асуудал эрхэлсэн орон тооны бус Ёс зүйн зөвлөл /цаашид “Ёс зүйн зөвлөл”/ хамтад нь /цаашид “Ёс зүйн зөвлөлүүд” гэх/ ажиллана.

1.3. Тухайн төрийн албан хаагчийн томилох дээд шатны байгууллагын Ёс зүйн зөвлөлүүд нь ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай гомдол, мэдээллийг тус тус харьяаллын дагуу шийдвэрлэнэ.

1.4. Ёс зүйн зөвлөлүүд нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм”, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллана.

Хоёр. Ёс зүйн зөвлөл, түүний бүрэлдэхүүн

2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийг нийт албан хаагчдын саналыг авсан 7 (дарга, гишүүд) гишүүний бүрэлдэхүүнтэй, аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг нийт албан хаагчдын саналыг авсан 3-7 (дарга, гишүүд) гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Ёс зүйн зөвлөлүүд Нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга саналын эрхгүй байна.

2.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн хэлтэс (газар)-ийн даргын тушаалаар тус тус томилно.

2.3. Ёс зүйн зөвлөлүүдийн гишүүдийг тухайн байгууллагын нийт албан хаагчдын саналыг үндэслэн 3 жилийн хугацаатайгаар томилно.

2.4. Ёс зүйн зөвлөлүүдийн даргыг гишүүдийн олонхийн саналаар томилно.

2.5. Ёс зүйн зөвлөлүүдийн дарга нь тухайн шатны байгууллагын даргаас бусад албан тушаалтан байна.

2.6. Ёс зүйн зөвлөлүүдийн гишүүн чөлөөлөгдсөн тохиолдолд Ёс зүйн зөвлөлийн дарга түүнийг нөхөн сонгох ажлыг 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

2.7. Тухайн байгууллагын төрийн албан хаагчийн тоо 25 хүрэхгүй бол ёс зүйн зөвлөл байгуулахгүй байж болно. Энэ тохиолдолд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан шалгаж, холбогдох танилцуулга, материалыг тухайн байгууллагын удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

Гурав. Ёс зүйн зөвлөлийн бүрэн эрх, үүрэг

3.1. Ёс зүйн зөвлөлүүд дараах эрх, үүрэгтэйгээр ажиллана. Үүнд:

3.1.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж, тогтоол гаргах;

3.1.2. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, төрийн албан хаагчдийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

3.1.3. Гомдол, мэдээллийг шалгахад шаардлагатай тайлбар, нотлох баримтыг холбогдох этгээдээс шаардан авах;

3.1.4. Гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах, шаардлагатай гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргагчийн аюулгүй байдлыг хангуулахаар холбогдох байгууллагад хандах;

3.1.5. Гомдол, мэдээллийг шалгасан тухай дүнг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналыг үндэслэн тогтоолоо хараат бусаар гаргах;

3.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөл нь Ёс зүйн зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

Дөрөв. Ёс зүйн зөрчил шалгах үндэслэл, харьяалал

4.1. Ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг дараах үндэслэлээр шалгана. Үүнд:

4.1.1. Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай ирүүлсэн гомдол, мэдээллийг харьяаллын дагуу;

4.1.2. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээллийг үндэслэн, Ёс зүйн зөвлөлүүдийн санаачлагаар болон байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу;

4.1.3. Шаардлагатай тохиолдолд Ёс зүйн зөвлөлийн даргын саналаар болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийн санаачлагаар.


Тав. Хуралдааны дэг

5.1. Ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

5.2. Хуралдааныг Ёс зүйн зөвлөлүүдийн даргын санаачлагаар товлон зарлана.

5.3. Хуралдааныг Ёс зүйн зөвлөлийн дарга удирдана. Түүний эзгүйд томилсон гишүүн орлоно.

5.4. Ёс зүйн зөвлөлүүдийн гишүүдийн ердийн олонхийн ирцтэйгээр хуралдаан хүчин төгөлдөр болно.



5.5. Ёс зүйн зөвлөлийн хуралдаанд зөрчил гаргасан гэж үзэж буй ажилтныг биеэр оролцуулж, тайлбар авч болно.

5.6. Ёс зүйн зөвлөлүүдийн гишүүнтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хэлэлцэх тохиолдолд тухайн гишүүнийг хуралд оролцуулахгүй.

5.7. Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүд дангаараа гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэхийг хориглоно.

5.8. Ёс зүйн зөвлөлийн Нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө.

Зургаа. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах, шалгаж шийдвэрлэх

6.1. Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсэх тухай гомдол, мэдээллийг бичиг хэргийн ажилтан хүлээн авч бүртгэн томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.

6.2. Томилох эрх бүхий албан тушаалтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсэхийг шалгуулахаар Ёс зүйн зөвлөлийн даргад шилжүүлнэ.

6.3. Ёс зүйн зөвлөлийн дарга нь Ёс зүйн зөвлөлөөс шалгах эрх бүхий Ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэг нь хууль тогтоомжийн хүрээнд шалгаж, санал, дүгнэлтээ Ёс зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

6.4. Ёс зүйн зөвлөлүүд нь хуралдааны тэмдэглэл, гишүүдийн саналыг үндэслэн тогтоол гаргах бөгөөд уг тогтоолд хуралдаанд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Саналын зөрүүтэй гишүүн саналаа бичгээр гаргаж, хуралдааны тэмдэглэлд хавсаргана.

6.5. Ёс зүйн зөвлөлүүд нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг тус тус хэрэглэнэ.

6.6. Тухайн шатны томилох эрх бүхий албан тушаалтан нь тогтоолыг үндэслэж шийдвэр гаргаж, холбогдох талуудад мэдэгдэнэ.

6.7. Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн нь гэмт хэргийн болон авлигын шинжтэй бол харьяаллын дагуу шалгуулахаар тэмдэглэл үйлдэж, холбогдох байгууллагад шилжүүлнэ.

Долоо. Ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

7.1. Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

Найм. Хүлээлгэх хариуцлага


8.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэнэ.

8.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн дараахь хариуцлага хүлээлгэнэ:

8.2.1. уучлал гуйхыг үүрэг болгох;

8.2.2. сануулах;

8.3. Төрийн албан хаагчийг сахилгын хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



8.4. Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан үйлдэлдээ дүгнэлт хийж, өөрийн хүсэлтээр сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

